



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 53

Номгон

“Баянхонгор хайрхан фарм” Орон нутгийн
өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж” дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 132 дугаар тогтоолоор “Баянхонгор хайрхан фарм” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын
02-ны өдрийн 53 дугаар тогтоолын хавсралт



**“БАЯНХОНГОР ХАЙРХАН ФАРМ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМД ОРУУЛАХ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1. Дүрмийн 2.2-д Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: “Баянхонгор сум Дуурсах 3-р баг, Эрүүл мэндийн газар” гэснийг “Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Баянхонгор сум Номгон 1-р баг, 96-р байр, 1 тоот” гэж өөрчлөх

2. Дүрмийн Дөрөв. “Газрын үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа явуулах хугацаа” гэснийг “Газрын үйл ажиллагааны чиглэл гэж өөрчлөх”

3. 4.1.а-д “Аймгийн сум багийн түвшинд хүн амд эмийн хангамж үйлчилгээг хүртээмжтэй тогтвортой байлгаж, эм эмнэлгийн тоног төхөөрөмжийг стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр байнга тасралтгүй хангана.” гэснийг “Аймаг, сум, багийн түвшний хүн амд эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж үйлчилгээг стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр тогтвортой, хүртээмжтэй тасралтгүй хангана” гэж өөрчлөх

4. 4.1.е-д “Эмийн санчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сайн ажилласан ажилчдыг шагнаж урамшуулах” гэснийг “Байгууллагын ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сайн ажилласан ажилчдыг шагнаж урамшуулах” гэж өөрчлөх

5. 4.1.ё-д Ядуу эмзэг бүлгийн иргэдэд бололцооны хэрээр дэмжлэг тусламж үзүүлэх” шинээр нэмж оруулах

6. 6.6.1. “Удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Нэгдсэн эмнэлгийн дарга, эмийн мэргэжилтэн, иргэний төлөөлөл” гэснийг

Удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

Аймгийн Засаг дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга,

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч,
Иргэний төлөөлөл” гэж өөрчлөх

7. 6.6.2.-д “Гүйцэтгэх захирал нь Удирдах зөвлөлийн анхны хурлыг удирдах зөвлөл сонгогдсноос хойш сарын дотор хуралдуулах ажлыг зохион байгуулна.” гэснийг Гүйцэтгэх захирал нь Удирдах зөвлөлийн анхны хурлыг удирдах зөвлөл сонгогдсноос хойш 45 хоногийн дотор хуралдуулах ажлыг зохион байгуулна.” гэж өөрчлөх

8. 6.2.-д “Дарга нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан байна” гэснийг “6.2. Захирлаар томиллогдох этгээд дор дурдсан шаардлага хангасан байвал зохино” гэснийг “Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан дараах шалгуурыг мөрдөнө.

1. Дээд боловсролтой

2. Удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг

3. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, эрүүгийн хуульд заасан санаатай гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, удирдаж байсан хуулийн этгээдээ дампууруулсан эсхүл удирдах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс өөрчлөгдсөн этгээдийг 5 жилийн дотор захирлаар томилохыг хориглоно.

4. Захирал төрийн, хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу нийтийн болон, шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно” гэж өөрчлөх